



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар

A/234

Улаанбаатар хот

Судалгааны удирдамж, арга аргачлал
батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.1.1, 4.7.6, 7.1.1 заалт, Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан 97/56 дугаар тушаалын 4.1.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх нь” судалгааны удирдамж, арга аргачлалыг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Судалгааг чанартай хийж шийдвэр гаргагчдыг үндэслэл, нотолгоотой мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн албаны дарга /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
3. Судалгааны төсвийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
19. өдрийн Дуушаалын нэгдүгээр хавсралт
1234



“ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ НЬ”
СУДАЛГААНЫ УДИРДАМЖ, АРГА АРГАЧЛАЛ

Үндэслэл: Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлэх үндсэн нөхцлүүдийн нэг нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил юм. Хүний нөөцийн хөгжлийг хангахын тулд хүний нөөцийг оновчтой төлөвлөх нь нэн чухал нь олон улсын туршлагаар нотлогдсон байна.

Ойрын болон алс, хэтийн ирээдүйд эрүүл мэндийн салбарт ажиллах шаардлагатай үндсэн мэргэжилийн эмчийн тоо, мэргэжлийн чиглэлийг эрүүл мэндийн салбарын бодлого, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийлүүлэн тооцох шаардлага эрүүл мэндийн салбарт тулгамдаж байгаа нь судалгааны ажил хийх үндэслэл юм.

2016 оны байдлаар эрүүл мэндийн салбарт 48173 ажилтан ажиллаж байгаагийн 10 мянга нь их эмч, 1.5 мянга нь эм зүйч, 18.5 мянга нь сувилагч, тусгай мэргэжилтэн байна. Сүүлийн 10 жилд үндсэн мэргэшлийн сургалтад 4133 их эмч 23 чиглэлээр хамрагджээ. Эрүүл мэндийн сайдын 2016 оны “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, мэргэжлийн индекс батлах тухай” А/184 дүгээр тушаалаар үндсэн мэргэшлийн сургалтын 33 чиглэл батлагдсан ба шинээр Хүүхдийн нүүр ам судлал, шүдний ерөнхий эмчилгээ судлал, шүдний сувгийн эмчилгээ судлал, шүдний тулгуур эд судлал, Ерөнхий мэргэшил судлал, зоонозын өвчин судлал болон нийгмийн эрүүл мэнд судлалын чиглэл нэмэгдсэн.

Статистик дүн мэдээнээс харахад их эмч хүртээмжтэй байгаа мэт харагдаж байгаа боловч зарим үндсэн мэргэшлийн их эмч, тухайлбал, Анатомийн эмгэг судлаач эмч, Өрхийн эмч, Сүрьеэгийн эмч дутагдалтай, Хүүхдийн нүүр амны, Шүдний ерөнхий эмчилгээний, Шүдний сувгийн эмчилгээний, Шүдний тулгуур эдийн, Ерөнхий мэргэшлийн, Зоонозын их эмчийг шинээр бэлтгэх зах зээлийн хэрэгцээ шаардлага гарч байна.

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх нь эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй үндсэн мэргэшлийн эмч нарын хүртээмж, сургалт эрхлэгч байгууллагын хүчин чадал, сургалтын орчинд үнэлгээ хийж, үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдал, хэрэгцээг тодорхойлох шаардлагатай.

ЗОРИЛГО

Үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх

ЗОРИЛТУУД

1. Үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдлыг үнэлэх
2. Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн судалгааг хийх.
3. Зарим бүсийн оношлогоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэгт үндсэн мэргэшлийн сургалт явуулах нөөцийн чадамжийг судлах, үнэлэх

СУДАЛГААНЫ АРГА БА ЗАГВАР

Судалгааны 1-р зорилтын хүрээнд

1. Баримтын болон агшингийн судалгааны загвараар үндсэн мэргэшлийн сургалт эрхэлдэг байгууллагуудын төгсөгчдийн тоо, мэргэшлийн чиглэл, хүний нөөцийн чадавхи, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ өгөх, хууль эрх зүйн бичиг баримтыг судлах. (Хүснэгтийг хавсаргав)
2. Бүлгийн ярилцлагаар сургагч багш болон суралцагчдаас урьдчилан бэлтгэсэн асуулгын тусламжтайгаар удирдан чиглүүлж, тэмдэглэл хөтлөн, нэгтгэн дүгнэх аргаар ярилцлагын үр дүнгээ үнэлэнэ. Нийт 5-н төрлийн үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдаж буй суралцагчид болон багш нарыг бүлгийн ярилцлаганд оролцуулна. (Бүлгийн удирдамжийг хавсаргав)
3. Асуумжын аргаар суралцагчдын сэтгэл ханамжийн байдлыг үнэлэнэ. (Асуумжыг хавсаргав)

Судалгааны 2-р зорилтын хүрээнд

1. Баримтын судалгааны аргаар Орон нутгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөц, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийнэ.

Судалгааны 3-р зорилтын хүрээнд

1. Ажиглалтын болон асуумж судалгааны аргаар байгууллагын чадамжид үнэлгээ өгнө. (ажиглалтын хуудсыг хавсаргав)

Судалгааны ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хугацаа
1.	Судалгааны удирдамж, арга аргачлал боловсруулж батлуулах	2017.11.24
2.	Судалгааны мэдээлэл цуглуулах	2017.11.27 - 2017.12.06
3.	Судалгааны мэдээлэл нэгтгэх	2017.12.06 - 2017.12.09
4.	Судалгааны дүнд дүн шинжилгээ хийх	2017.12.09 - 2017.12.11
5.	Судалгааны үр дүнгийн тайлан бичих	2017.12.11 - 2017.12.15
6.	Судалгааны үр дүнг хэлэлцүүлэх	2017.12.15 - 2017.12.20

СУДАЛГААНЫ ХҮРЭЭ БА ТҮҮВЭР

Үндсэн мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг 16 байгууллага, тэдгээрт суралцаж буй 1, 2 дугаар дамжааны оюутнууд болон Орхон, Дорнод аймгийн БОЭТ, Булган аймгийн нэгдсэн эмнэлэгийг хамруулна.

ҮР ДҮНГИЙН СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТ

Үнэлгээний мэдээллийн өгөгдлийг кодлох, шивэх, алдааг шалгах ажиллагааг стандартчилсны дараа өгөгдлийг "SPSS 17.0" програм ашиглан боловсруулж үр дүнд дескриптив статистик шинжилгээ хийнэ. Чанарын судалгааны мэдээлэлд үр дүнг агуулгаар бүлэглэн нэгтгэх аргыг хэрэглэнэ.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Сургалт эрхлэгч байгууллагын өнөөгийн байдал, орон нутаг дахь үндсэн мэргэшил эзэмшсэн хүний нөөцийг одоогийн байдлыг судалж, сургалт эрхлэх байгууллага, үндсэн мэргэшлийн сургалтын мэргэшлийн чиглэл, шаардлагатай мэргэжилтний хэрэгцээг тооцох суурь судалгаа болно.